



Аудитын код: САГ-2017/19/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261740 Цахим хаяг: sambuunyamyaa@audit.gov.mn

Аудитор Б.Баярмаа

Утас: 260512 Цахим хаяг: bayarmaab@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	6
2.6	Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн талаарх тайлбар.....	7
2.7	Шилэн дансны мэдээлэл	8
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Аудитын залруулга бичилтийн талаар.....	9
2.9.2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон санхүүгийн програм хангамжийн талаар	9
2.9.3	Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар	9
2.9.4	Бараа материалын бүртгэлийн талаар.....	9
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	10
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	10
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал.....	12
3.1	Аудитын залруулга бичилтийн талаар.....	13
3.2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон санхүүгийн програм хангамжийн талаар	14
3.3	Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар	15
3.4	Бараа материалын бүртгэлийн талаар.....	16
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	17
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	17
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	18
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	20
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21

1 Аудитын гэрчилгээ



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 04. 25 № 772

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА С.ДАВААСҮРЭН
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Зөрчилгүй санал дүгнэлт

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбогдох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 05-наас 2017 оны 4 дүгээр сарын 21-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Баярмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 3/1098 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн боловч санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу тайлан гаргаж ирүүлээгүй тул дахин засварлуулж 2017 оны 4 дүгээр сарын 17-ны 3/1196 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Санхүүгийн зохицуулах хорооны эрхэм зорилго нь Монгол Улсад олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагаа бүхий санхүүгийн салбарыг хөгжүүлэх явдал юм.

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага бөгөөд холбогдох хуулийн хэрэгжилт болоод өөрийн үйл ажиллагааныхаа талаар жил тутам Улсын Их Хуралд тайлагнадаг, түүний харьяа байгууллага юм.

Санхүүгийн зохицуулах хороо нь 7 газар, 4 хэлтэс, 2 албатайгаар нийт 137 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус хороо нь дараах хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай;
- Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль;
- Даатгалын тухай хууль;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай;
- Хоршооны тухай хууль;
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль;
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай;
- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- 2016 оны төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль зэрэг хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 5 чиглэлээр түүвэрчилсэн 5 горим, сорил гүйцэтгэв.

Үүнээс гадна санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэх НББ-ийн бодлогын баримт бичгийг 2010 онд боловсруулж баталсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулахад санхүүгийн “Emerald” програмыг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргаж, СЗХ-нд нэгтгэгддэг төслийн тайланг “MS-Excel”-ээр нэгтгэсэн байна.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Санхүүгийн зохицуулах хорооны дотоод хяналтын хэлтэс 2 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Тайлант хугацаанд дотоод хяналтын хэлтсээс ажлын

албаны зарим нэгжүүдийн гүйцэтгэх чиг үүргийн хэрэгжилт, Хорооны дарга болон ажлын албаны даргын шийдвэр хэрэгжилт, 2015, 2016 оны хариутай бичиг өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, Улсын байцаагчийн үйл ажиллагаа, Ажлын албаны болон газруудын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт зэрэгт хяналт, үнэлгээ хийж, гүйцэтгэх үүргээр Хорооны даргын албан даалгаврыг өгч ажилласан боловч үндсэн хөрөнгө, бараа материалд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

2.6 Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлогоос 822.4 сая төгрөг, гадаад тусламжийн орлогоос 212.2 сая төгрөг нийт 1,034.6 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд орлогын төлөвлөгөөг 32 хувиар давуулан биелүүлж нийт 1,365.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2016 оны үйл ажиллагааны урсгал зардлыг нийт 2,909.7 сая төгрөгөөр батласны 64.4 хувь буюу 1,875.1 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр, 35.6 хувь буюу 822.4 сая төгрөгийг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр төлөвлөсөн байна.

Үүнээс тайлант хугацаанд улсын төсвөөс 1,735.9 сая төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 1,365.5 сая төгрөг бүрдүүлж, нийт 3,101.4 сая төгрөгийн эх үүсвэрээс гүйцэтгэлээр 2,675.7 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, улсын төсөвт 425.7 сая төгрөг төвлөрүүлэн батлагдсан төсвийг 8.0 хувиар хэмнэсэн байна

2016 оны санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн нийт мөнгөн орлогын дүн 7,189.2 сая төгрөг байна. Үүнийг задаргаагаар харуулбал:

д/д	Үзүүлэлт	Орлогын дүн /сая төг/
1	Улсын төсвийн санхүүжилт	1,735.9
2	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,201.6
3	Туслах үйл ажиллагааны орлого	3,857.3
4	Торгуулийн орлого	77.8
5	Төслийн санхүүжилт	172.6
6	Нэмэлт санхүүжилт	59.5
7	Улсын тэмдэгтийн хураамжийн орлого	57.1
8	Нийгмийн даатгалын сангаас	25.7
9	Бусад орлого	1.7
	Нийт орлого	7,189.2

Санхүүгийн зохицуулах хорооны үндсэн үйл ажиллагааны орлого 1,201.6 сая төгрөг нь Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоо, Даатгалын байгууллага, Үнэт цаасны зах зээлд оролцогчийн зохицуулалтын үйлчилгээнээс орох орлогоос бүрддэг байна.

Туслах үйл ажиллагааны орлогоор тайлагнасан 3,857.3 сая төгрөг нь тусгай зөвшөөрөл хүсэгчдийн дүрмийн сангийн баталгаагаар түр байршуулсан орлого байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагааны мөнгөн зарлагын хэмжээ нийт 7,494.9 сая төгрөг байгаагаас үйл ажиллагааны урсгал зардалд 2,603.3 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 4,891.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Урсгал шилжүүлгийн 86.3 хувь буюу 4,221.7 сая төгрөгийг 2015 оны дүрмийн сангийн буцаалтын өглөг болон 2016 оны дүрмийн сангийн буцаалтад, 8.7 хувь буюу 425.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн шилжүүлэг, бусад 5.0 хувь буюу 243.0 сая төгрөгийг нийгмийн даатгал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж зэрэг эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны “Журам батлах тухай” 29 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны даргын шилэн дансны нэгдсэн сайтад дараах мэдээлэл оруулсан байна.

- “Төсөв” цэсний Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, Дараа жилийн төсвийн төсөл, Санхүүгийн тайлан зэрэг мэдээллийг тус тус 1 удаа;
- “Төсөв” цэсний Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн мэдээг тус тус 12 удаа;
- “Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт” цэсэнд МУ-ын 2016 оны төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөв батлагдаагүй тул хамааралтай мэдээлэл байхгүй;
- “Бусад” цэсний Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл....төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт хороон даргын хөрөнгөтэй холбоотой захирамжийг сар бүр мэдээлж ажилласан байна.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Санхүүгийн зохицуулах хороотой холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 12 дансанд эрсдэлийн үнэлгээ хийж, үүнээс 5 дансанд эрсдэлтэй гэж үзэн батламж мэдэгдлүүдийн хүрээнд нийт 5 нарийвчилсан горим сорил гүйцэтгэлээ.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Аудитын залруулга бичилтийн талаар

Улсын төсөвт төвлөрүүлсэн 425.7 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс бууруулж, урсгал шилжүүлгийн зардалд бичиж тайлант үеийн үр дүнг бууруулан залруулав.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэсэн заалтыг мөрдөж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.9.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон санхүүгийн програм хангамжийн талаар

Санхүүгийн зохицуулах хорооны санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2010 онд боловсруулагдсанаас хойш нэмэлт шинэчлэл хийгээгүй байна. Мөн санхүүгийн “Emerald” програмыг ашиглаж байгаа нь ААН-ийн зориулалттай тул төсвийн байгууллагын бүртгэл, тайлангийн шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2017 онд мөрдөгдөж байгаа Сангийн сайдын тушаалаар батлагдсан журам, заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлтэй уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулах, санхүүгийн програм хангамжийг төсвийн байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцүүлж сайжруулах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.9.3 Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар

Төрийн өмчийн хороог татан буулгах комиссын 2016 оны 03 дугаар шийдвэрээр 52 нэр төрлийн 45.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий тавилга, техник хэрэгсэл; Санхүүгийн зохицуулах хорооны АА-ны даргын 2016 оны 79 дугаар тушаалаар тус хороонд нэгтгэгддэг төслөөс 8.0 сая төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгө, 37.9 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, нийт 91.5 сая төгрөгийн хөрөнгийг тус тус СЗХ-ны балансад шилжүүлэх шийдвэр гарсан боловч тайлант хугацаанд 45.7 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 45.8 сая төгрөгийн хөрөнгө орлогод аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн тооллого бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэн ажиллах, үндсэн хөрөнгийн орлогыг данс бүртгэлд тусгах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.9.4 Бараа материалын бүртгэлийн талаар

Бараа материалын дансанд биетээр байхгүй, байгууллагаас авах авлагын 2.1 сая төгрөгийн түлш, шатах тослох материалыг дансны үлдэгдлээр тайлагнасан; Сангийн сайдын 2016 оны 131 дүгээр тушаалаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 8.0 сая төгрөгийн компьютерийн рам, хард, ном зэргийг эргэлтийн хөрөнгийн дансанд шилжүүлэх шийдвэр гарсныг үндсэн хөрөнгийн данснаас хассан боловч бараа материалын дансанд орлогоор аваагүй зэрэг нийт 10.1 сая төгрөгийн зөрчил байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын дансны үлдэгдэлд бүртгэсэн 2.1 сая төгрөгийг дансны авлагаар бүртгэж залруулах; Үндсэн хөрөнгийн данснаас хасагдсан бараа материалыг орлогод авч данс бүртгэлд тусгах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц бусад чухал асуудал ажиглагдсангүй.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийх аудитаар өөрийн орлогын бүрдүүлэлт, үндсэн хөрөнгө, бараа материалд бодитой оршин байгаа эсэхэд горим хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 481.6 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, аудитын явцад 425.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 55.9 сая төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар зөвлөмж өглөө.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, менежментийн захидлаар 5 зөвлөмж өгсөнийг 100 хувь биелүүлсэн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн материаллаг байдлын суурийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 2 хувь 62.9 сая төгрөгөөр тооцож, төлөвлөлтийн шатанд тооцсон суурь үзүүлэлт болон түвшинг гүйцэтгэлийн шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын

баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан болно.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Аудитын залруулга бичилтийн ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Улсын төсөвт төвлөрүүлсэн 425.7 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс бууруулж, урсгал шилжүүлгийн зардалд бичиж тайлант үеийн үр дүнг бууруулан залруулав.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” гэсэн заалтыг мөрдөж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон санхүүгийн програм хангамжийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн зохицуулах хорооны санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2010 онд боловсруулагдсанаас хойш нэмэлт шинэчлэл хийгээгүй байна. Мөн санхүүгийн “Emerald” програмыг ашиглаж байгаа нь ААН-ийн зориулалттай тул төсвийн байгууллагын бүртгэл, тайлангийн шаардлагыг бүрэн хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуй нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтын дагуу Сангийн сайдын тушаалаар батлагдсан 2017 онд мөрдөгдөж байгаа журам, заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлтэй уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулах; Санхүүгийн програм хангамжийг төсвийн байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцүүлж сайжруулах;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэлгээ, үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан.

3.3 Үндсэн хөрөнгийн бүртгэлийн ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Төрийн өмчийн хороог татан буулгах комиссын 2016 оны 03 дугаар шийдвэрээр 52 нэр төрлийн 45.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий тавилга, техник хэрэгсэл; Санхүүгийн зохицуулах хорооны АА-ны даргын 2016 оны 79 дугаар тушаалаар тус хороонд нэгтгэгддэг төслөөс 8.0 сая төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгө, 37.9 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, нийт 91.5 сая төгрөгийн хөрөнгийг тус тус СЗХ-ны балансад шилжүүлэх шийдвэр гарсан боловч тайлант хугацаанд 45.7 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 45.8 сая төгрөгийн хөрөнгө орлогод аваагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Үндсэн хөрөнгийн тооллого бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэн ажиллах, үндсэн хөрөнгийн орлогыг данс бүртгэлд тусгах;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд оршин байх, иж бүрэн байх, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан.

3.4 БАРАА МАТЕРИАЛЫН БҮРТГЭЛИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Бараа материалын дансанд биетээр байхгүй, байгууллагаас авах авлагын 2.1 сая төгрөгийн түлш, шатах тослох материалыг дансны үлдэгдлээр тайлагнасан; Сангийн сайдын 2016 оны 131 дүгээр тушаалаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 8.0 сая төгрөгийн компьютерийн рам, хард, ном зэргийг эргэлтийн хөрөнгийн дансанд шилжүүлэх шийдвэр гарсныг үндсэн хөрөнгийн данснаас хассан боловч бараа материалын дансанд орлогоор аваагүй зэрэг нийт 10.1 сая төгрөгийн зөрчил байна

ҮАГ-ын зөвлөмж

Бараа материалын дансны үлдэгдэлд бүртгэсэн 2.1 сая төгрөгийг дансны авлагаар бүртгэж залруулах;
Бараа материалын тооллого бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэн ажиллах;
Үндсэн хөрөнгийн данснаас шилжүүлсэн бараа материалыг орлогод авч данс бүртгэлд тусгах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд оршин байх, иж бүрэн байх, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

Тайлангийн үзүүлэлт	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	385,450.4	49,343.5
МӨНГӨН ХӨРӨНГӨ	312,615.3	6,882.8
АВЛАГА	37,240.5	7,818.3
БАРАА МАТЕРИАЛ	35,594.7	34,642.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,013,012.5	742,423.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,013,012.5	742,423.4
Биет хөрөнгө	692,198.7	522,356.5
Биет бус хөрөнгө	320,813.8	220,066.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,398,463.0	791,766.9
НИЙТ ӨР ТӨЛБӨР	237,079.0	1,930.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	237,079.0	1,930.0
Өглөг	237,079.0	1,930.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,161,384.0	789,836.9
Засгийн газрын хувь оролцоо	1,161,384.0	789,836.9
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	569,052.4	569,052.4
Хуримтлагдсан үр дүн	502,794.4	131,247.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,537.1	89,537.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,398,463.0	791,766.9

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

Тайлангийн үзүүлэлт	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,988,797.7	3,155,297.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,240,226.6	1,419,408.2
Нийтлэг татварын бус орлого	1,148,338.4	1,228,340.5
Тусламжийн орлого	1,091,888.2	191,067.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,748,571.1	1,735,889.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,542,080.6	3,513,284.6
УРСГАЛ ЗАРДАЛ	4,542,080.6	3,513,284.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,250,001.4	2,870,048.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,712,878.2	1,639,663.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	178,928.2	181,803.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	253,268.3	206,417.6
Хангамж, бараа материалын зардал	264,899.9	113,810.1
Эд хогшил, урсгал засварын зардал	183,105.9	5,116.6
Томилолт, зочны зардал	83,747.0	92,985.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	725,617.1	271,561.9
Бараа үйлчилгээний бусад зардал	847,556.9	358,689.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	292,079.2	643,236.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-553,283.0	-357,987.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	13,560.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-553,283.0	-371,547.1

4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч/
2014 оны 12-р сарын 31-нээрх	1,316,704.9	0.0	1,316,704.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	397,962.1	0.0	397,962.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,714,666.9	0.0	1,714,666.9
Тайлант үеийн үр дүн	-553,283.0	0.0	-
2015 оны 12-р сарын 31-нээрх	1,161,384.0	0.0	1,161,384.0
2016 оны 1-р сарын 1-нээрх	1,161,384.0	0.0	1,161,384.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,161,384.0	0.0	1,161,384.0
Тайлант үеийн үр дүн	-371,547.1	0.0	-
2016 оны 12-р сарын 31-нээрх	789,836.9	0.0	789,836.9

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

Тайлангийн үзүүлэлт	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	74,686,985.2	7,189,206.8
ТАТВАРЫН ОРЛОГО	81,052.0	57,133.5
Бусад татвар, төлбөр, хураамж	81,052.0	57,133.5
Бусад нийтлэг төлбөр, хураамж	81,052.0	57,133.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	72,510,649.8	5,310,958.9
Нийтлэг татварын бус орлого	71,509,337.8	5,138,309.1
Тусламжийн орлого	1,001,312.0	172,649.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,095,283.4	1,821,114.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,374,384.6	7,494,939.3
УРСГАЛ ЗАРДАЛ	74,374,384.6	7,494,939.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,976,209.7	2,603,336.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,619,535.2	1,638,742.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,738.7	183,802.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	268,636.6	191,717.6
Хангамж, бараа материалын зардал	291,955.2	69,268.9
Эд хогшил, урсгал засварын зардал	94,730.3	5,934.5
Томилолт, зочны зардал	284,242.4	78,268.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	948,653.3	177,549.2
Бараа үйлчилгээний бусад зардал	285,718.0	258,053.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,398,175.0	4,891,602.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	312,600.6	-305,732.5
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	312,600.6	-305,732.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14.7	312,615.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	312,615.3	6,882.8

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,909,694.6	2,675,729.6	233,965.0	92.0
УРСГАЛ ЗАРДАЛ	2,909,694.6	2,675,729.6	233,965.0	92.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,541,443.7	2,458,451.2	82,992.5	96.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,700,268.2	1,638,742.6	61,525.6	96.4
Үндсэн цалин	1,479,857.3	1,356,965.2	122,892.1	91.7
Нэмэгдэл	135,372.1	94,723.9	40,648.2	70.0
Унаа хоолны хөнгөлөлт	85,038.8	187,053.5	-102,014.7	220.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	196,012.7	191,717.6	4,295.1	97.8
Байрны түрээс	196,012.7	191,717.6	4,295.1	97.8
Хангамж, бараа материалын зардал	69,354.7	69,268.9	85.8	99.9
Бичиг хэрэг	13,975.5	24,392.5	-10,417.0	174.5
Тээвэр, шатахуун	16,277.0	16,276.9	0.1	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	39,102.2	22,680.3	16,421.9	58.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.0	5,919.1	-5,919.1	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	12,366.6	5,934.5	6,432.1	48.0
Багаж, техник, хэрэгсэл	137.7	137.7	0.0	100.0
Урсгал засвар	12,228.9	5,796.8	6,432.1	47.4
Томилолт, зочны зардал	18,786.4	18,786.4	0.0	100.0
Гадаад албан томилолт	0.0	12,142.3	-12,142.3	0.0
Дотоод албан томилолт	18,786.4	6,644.1	12,142.3	35.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	179,632.0	177,549.2	2,082.8	98.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	153,505.6	151,440.4	2,065.2	98.7
Даатгалын үйлчилгээ	6,352.0	6,334.3	17.7	99.7
Тээврийн хэрэгслийн татвар	19,324.4	19,324.4	0.0	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.0	0.0	0.0	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.0	0.0	0.0	0.0
Газрын төлбөр	450.0	450.0	0.0	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	181,221.0	172,649.9	8,571.1	95.3
Бараа үйлчилгээний бусад зардал	181,221.0	172,649.9	8,571.1	95.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	368,250.9	217,278.5	150,972.4	59.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	270,137.3	142,702.8	127,434.5	52.8
Засгийн газрын гадаад шилжүүлэг	270,137.3	142,702.8	127,434.5	52.8
Бусад урсгал шилжүүлэг	98,113.6	74,575.7	23,537.9	76.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	44,392.0	41,685.0	2,707.0	93.9

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,721.6	32,890.7	20,830.9	61.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,909,694.6	2,675,729.6	233,965.0	92.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,875,073.6	1,310,181.7	564,891.9	69.9
Улсын төсвөөс санхүүжих	1,875,073.6	1,310,181.7	564,891.9	69.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	822,400.0	1,192,898.1	-370,498.1	145.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	822,400.0	1,192,898.1	-370,498.1	145.1
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	212,221.0	172,649.9	39,571.1	81.4
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	212,221.0	172,649.9	39,571.1	81.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	312,615.3	-312,615.3	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	6,882.8	-6,882.8	0.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	289.0	275.0	14.0	95.2
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	0.0	100.0
Төсвийн байгууллага	1.0	1.0	0.0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	144.0	137.0	7.0	95.1
Удирдах ажилтан	19.0	19.0	0.0	100.0
Гүйцэтгэх ажилтан	115.0	85.0	30.0	73.9
Үйлчлэх ажилтан	10.0	11.0	-1.0	110.0
Гэрээт ажилтан	0.0	22.0	-22.0	0.0